



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/177

Сүхбаатар сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."г", 29.2, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэр Ширээ нурууны суурьшлын бүсэд газар ашиглуулж, эзэмшүүлж, өмчлүүлж буй үйл ажиллагаа, иргэдийн үл хөдлөх эд хөрөнгийг банк санхүүгийн байгууллагад барьцаалах, эдийн засгийн эргэлтэд оруулах, эрх бүхий иргэний харьяаллаас хамааран хязгаарлагдаж байгаа эсэх, малын хулгай болон гэмт хэргийн гаралт, түүний шийдвэрлэлтийн байдал, голын эрэг дагуух олгогдсон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл зэрэг салбар бүрийн асуудлуудыг газар дээр нь шалгаж, нарийвчилсан судалгаанд үндэслэж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Саруултөгс

-Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга

Нарийн бичгийн дарга:

Г.Мөнх-Эрдэнэ

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд:

Д.Ёндонжамц

- Хуугь, эрх зүйн хэлтсийн дарга

А.Эрдэнэгэрэл

-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Б.Саранчимэг

-Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

Б.Мөнхсоёл

-Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга

Б.Баярмаа

- Мэргэжлийн хяналтын газрын Газрын харилцаа, геодези, зурагзүйн хяналтын улсын байцаагч

Б.Оюун-Эрдэнэ	- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Газар, газрын хэвлий, уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэн
С.Чулуунцэцэг	- Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн
О.Буянаа	-Сайхан сумын Засаг дарга
Э.Батмөнх	-Сайхан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга
Б.Энхчулуун	- Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн дарга

2.Газар дээр нь үзэж тодруулан нарийвчилсан судалгааг салбар бүрээр гаргах, цаашид авах арга хэмжээг тодорхойлох ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж, ажлын хэсгийн үр дүнг 2020 оны 09 дүгээр сарын 15–ны дотор аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Саруултөгс/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



ШОРГИЛ